

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 4/46

Өлгий

Г

Т

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дэргэдэх “Ахмадын хороо”-ны журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга /Ш.Иманхан/-д даалгасугай.



Эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны 10 сарын 04 ёдрийн 4/46 тоот  
тушаалтын 11 наадам хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АХМАДЫН

### ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

#### 1 дүгээр зүйл. Журмын зорилго

1. Энэхүү журмаар Эрүүл мэндийн газрын дэргэдэх ахмадын хороо /цаашид “ахмадын хороо” гэнэ/-ны зохион байгуулалт, үйл ажиллагаа, ахмадуудын эрх ашгийг хамгаалах, тусlamж, дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

#### 2 дугаар зүйл. Ахмадын хорооны зохион байгуулалт

2.1. Ахмадын хороо нь энэ журмын 3.2.1, 3.2.2-т заагдсан болзол, шаардлагыг хангасан ахмадуудыг эгнээндээ нэгтгэсэн; ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх; ахмадуудын эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах зорилготой эрүүл мэндийн газрын дэргэдэх ахмадын хороо /цаашид “сан” гэнэ/ байна.

#### 3 дугаар зүйл. Ахмадын хорооны гишүүн, түүний бүртгэл

3.1. Ахмадын хороонд бүртгэж, үнэмлэх олгосноор “ахмадын хорооны гишүүн” болно.

3.2. Ахмадын хороонд бүртгүүлэх хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд дор дурдсан баримтыг хавсаргасан байна:

3.2.1. Анкет;

3.2.2. Иргэний үнэмлэхийн хуулбар;

3.2.3. Тэтгэврийн дэвтрийн хуулбар;

#### 4 дүгээр зүйл. Ахмадын хорооны үйл ажиллагаа

4.1. Ахмадын хороо дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

4.1.1. Холбоо, салбар зөвлөлөөс явуулж буй үйл ажиллагаанд оролцох;

4.1.2. Ахмадын хорооны гишүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд зориулан хүндэтгэлийн болон нийгэм, соёлын арга хэмжээг зохион байгуулах;

4.1.3. Ахмадын хорооны гишүүний санал, хүсэлтийг хүлээн авч, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

4.1.4. Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэх;

4.1.5. Бусад.

#### 5 дугаар зүйл. Ахмадын сангийн санхүүжилт

5.1. Ахмадын сангийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 5.1.1. Нийт цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсэн хөрөнгө;
- 5.1.2. Хандив, тусlamж;
- 5.1.3. Сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл хөрөнгө.
- 5.1.4 . Бусад эх үүсвэр

#### **6 дугаар зүйл . Сангийн хөрөнгийн зарцуулалт**

Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1 , 14.6-д заасан дараах арга хэмжээнд зарцуулна:

- 6.1. Цагаан сар, Наурызын баяр, Ахмадын өдрийг тохиолдуудан хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйл гардуулах,
- 6.2 .Нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлш худалдан авахад нь зориулан жил бүр Засгийн газраас тогтоосон хэмжээгээр мөнгөн дэмжлэг үзүүлэх,
- 6.3. Эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд нь зориулж мөнгөн тусlamж үзүүлэх,
- 6.4. Ахмад настан өөрөө эсхүл түүний нөхөр /эхнэр/ нас барсан тохиолдолд мөнгөн дэмжлэг үзүүлэх
- 6.5.Ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулах

#### **7 дугаар зүйл . Сангийн хөрөнгийн хяналт, тайлагналт**

- 7.1. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад мэргэжлийн хяналт, аудит, санхүүгийн байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.
- 7.2. Ахмад настанд тусlamж, дэмжлэг олгох, сангийн гүйцэтгэлийг тайлагнах асуудлыг тухайн байгууллагын санхүү болон ахмадын хороо хамтран хариуцан гүйцэтгэнэ.
- 7.3. Байгууллагын захиргаа нь сангийн орлого, зарлагын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаргаж, байгууллагын дэргэдэх ахмадын хороонд тайлагнана.